



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын нэгдсэн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/174/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2022 он

*Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,*

*Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*

*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*

*Аудитын менежер: И.Сэмжидмаа*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*

*Ахлах аудитор: Д.Нармандах*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn*

*Аудитор: А.Даваасүрэн*

*Утас: 70003775, 88883776*

*Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ЗГ	Засгийн газар
НА	Нотлох аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 2/2  
танай -ны № -т

ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ц.БАТБАЯР ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын нэгдсэн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын нэгдсэн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ 011020965

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>11,918,219,720.34</u></b>	<b><u>15,366,038,953.70</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	5,462,330,812.70	6,870,806,619.02
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	5,462,330,812.70	6,870,806,619.02
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	5,462,330,812.70	6,870,806,619.02
31211	Төрийн сангийн харилцах	17,335,269.15	377,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	5,444,995,543.55	6,870,429,120.12
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		498.90
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,425,989,592.64	8,462,150,469.28
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	440,520,290.72	985,511,387.02
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,968,914,972.64	7,476,148,966.55
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	16,554,329.28	490,115.71
3351	Байгууллагаас авах авлага	16,554,329.28	490,115.71
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	29,899,315.00	33,081,865.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	29,899,315.00	33,081,865.40
35410	Бичиг хэргийн материал	3,412,424.00	3,448,225.40
35420	Аж ахуйн материал	21,451,353.00	24,876,960.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,804,000.00	1,804,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,231,538.00	2,952,680.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>418,537,066.57</u></b>	<b><u>397,019,405.36</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	418,537,066.57	397,019,405.36
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	374,537,066.57	353,019,405.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	341,926,799.99	341,926,799.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,900,678.38)	(44,852,094.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,800,000.00	69,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(65,922,222.23)	(69,800,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,576,830.00	135,354,084.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,319,371.14)	(96,565,672.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,544,200.00	59,544,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,168,491.67)	(42,387,911.67)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	44,000,000.00	44,000,000.00
39301	Програм хангамж	3,103,332.00	3,103,332.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,103,332.00)	(3,103,332.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,000,000.00	44,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>12,336,756,786.91</u></b>	<b><u>15,763,058,359.06</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>146,915,805.10</u></b>	<b><u>105,933,927.76</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	146,915,805.10	105,933,927.76
<b>413</b>	<b>Өглөг</b>	31,710,844.39	12,592,465.53
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,590,770.39	12,592,465.53
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,120,074.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,120,074.00	
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	115,204,960.71	93,341,462.23
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	115,204,960.71	93,341,462.23

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>12,189,840,981.82</u></b>	<b><u>15,657,124,431.30</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	12,189,840,981.82	15,657,124,431.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	280,092,839.30	280,092,839.30
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	11,792,240,043.97	15,259,523,493.45
51210	Өмнөх үеийн үр дүн	3,467,290,398.17	11,816,679,233.14
51220	Тайлант үеийн үр дүн	8,324,949,645.80	3,442,844,260.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,508,098.55	117,508,098.55
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>12,336,756,786.92</b>	<b>15,763,058,359.06</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>107,583,315,882.23</b>	<b>79,702,964,812.10</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>39,518,599,841.28</b>	<b>43,720,595,250.44</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	39,518,599,841.28	43,720,595,250.44
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,418,747,000.64	30,701,217,224.12
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,757,566,595.69	2,947,662,833.09
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,409,007,733.53	2,602,477,374.18
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	511,783,450.40	550,922,813.77
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,421,495,061.02	6,918,315,005.28
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>90,723,591.47</b>	<b>29,509,897.66</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	90,723,591.47	29,509,897.66
120002	Хүүгийн орлого	70,893,384.70	9,484,953.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,970,206.77	12,001,843.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,921,106.77	10,950,989.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,049,100.00	1,050,854.54
120009	Бусад орлого	5,860,000.00	8,023,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>67,973,992,449.48</b>	<b>35,952,859,664.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	365,000,000.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	365,000,000.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,960,000.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,960,000.00	285,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	66,936,227,249.48	35,313,231,864.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,936,227,249.48	35,313,231,864.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	668,805,200.00	639,342,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	668,805,200.00	639,342,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>99,258,366,236.43</b>	<b>76,260,120,551.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>99,258,366,236.43</b>	<b>76,260,120,551.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	663,985,689.63	657,444,264.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	459,901,839.00	482,044,844.50
210101	Үндсэн цалин	359,174,251.00	374,421,312.50
210102	Нэмэгдэл	78,857,588.00	83,095,533.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,880,000.00	19,228,000.00
210104	Урамшуулал	3,990,000.00	5,299,998.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,727,882.46	62,778,944.00
210201	Тэтгэврийн даатгал	38,643,044.52	43,436,751.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,774,095.88	4,833,978.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,815,813.03	3,867,182.95
210204	Ажилгүйдлийн даатгал	952,510.06	966,795.74
210205	Эрүүл мэндийн даатгал	9,542,418.97	9,674,235.27
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,426,087.11	8,786,126.70
210301	Гэрэл, цахилгаан	2,862,991.57	2,691,172.10
210302	Түлш, халаалт	5,530,175.54	5,004,839.61

Нийгмийн даатгалын нэгдсэн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	1,032,920.00	1,090,114.99
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,975,565.88</b>	<b>17,373,095.47</b>
210401	Бичиг хэрэг	3,823,364.00	5,253,648.60
210402	Тээвэр, шатахуун	7,177,926.00	7,813,711.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,184,260.88	1,331,712.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	245,800.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,544,215.00	2,874,023.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,913,100.00</b>	<b>3,881,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,805,800.00	1,830,000.00
210604	Урсгал засвар	107,300.00	2,051,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,980,400.00</b>	<b>208,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,980,400.00	208,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>53,366,529.77</b>	<b>41,437,958.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,485,030.17	30,796,080.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,520,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	831,300.00	1,199,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,300.00	71,620.00
210807	Газрын төлбөр	126,720.00	126,720.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,526,730.00	5,613,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,765,449.60	3,630,338.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>59,694,285.41</b>	<b>40,933,995.22</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,447,000.00	2,089,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,247,285.41	38,844,945.22
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>98,594,380,546.80</b>	<b>75,602,676,287.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,504,630,035.00</b>	<b>66,835,362,016.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	63,434,433,215.00	66,825,388,718.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,520,220.00	9,973,298.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,676,600.00	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>35,089,750,511.80</b>	<b>8,767,314,271.50</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,089,750,511.80	8,767,314,271.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>8,324,949,645.80</u></b>	<b><u>3,442,844,260.31</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>8,324,949,645.80</u></b>	<b><u>3,442,844,260.31</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	280,092,839.30	117,508,098.55	3,439,715,796.42	3,837,316,734.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			27,574,601.75	27,574,601.75
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>280,092,839.30</b>	<b>117,508,098.55</b>	<b>3,467,290,398.17</b>	3,864,891,336.02
Тайлант үеийн үр дүн			8,324,949,645.80	8,324,949,645.80
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>280,092,839.30</b>	<b>117,508,098.55</b>	<b>11,792,240,043.97</b>	12,189,840,981.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			24,439,189.17	24,439,189.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>280,092,839.30</b>	<b>117,508,098.55</b>	<b>11,816,679,233.14</b>	12,214,280,170.99
Тайлант үеийн үр дүн			3,442,844,260.31	3,442,844,260.31
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>280,092,839.30</b>	<b>117,508,098.55</b>	<b>15,259,523,493.45</b>	15,657,124,431.30

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>101,867,778,020.28</b>	<b>77,682,117,085.21</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>34,092,543,637.76</b>	<b>41,552,681,322.91</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	34,092,543,637.76	41,552,681,322.91
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,253,895,932.10	29,726,077,031.24
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,180,398,538.51	2,456,072,826.23
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,816,268,987.49	2,091,616,377.23
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	401,927,561.12	456,533,840.96
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,440,052,618.54	6,822,381,247.25
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>198,163,951.24</b>	<b>87,447,062.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	198,163,951.24	87,447,062.30
120002	Хүүгийн орлого	70,893,384.70	9,484,953.74
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	127,270,566.54	77,962,108.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,221,466.54	76,911,254.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,049,100.00	1,050,854.54
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>67,577,070,431.28</b>	<b>36,041,988,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	109,875,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		109,875,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,960,000.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,960,000.00	285,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	66,904,305,231.28	35,292,485,300.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,904,305,231.28	35,292,485,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	668,805,200.00	639,342,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	668,805,200.00	639,342,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>99,385,302,215.91</b>	<b>76,273,641,278.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>99,385,302,215.91</b>	<b>76,273,641,278.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>653,679,468.62</b>	<b>618,430,389.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	459,901,839.00	482,044,844.50
210101	Үндсэн цалин	345,448,138.40	356,252,002.90
210102	Нэмэгдэл	89,536,700.00	98,959,049.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,927,000.60	21,533,794.40
210104	Урамшуулал	3,990,000.00	5,299,998.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,727,882.46	62,778,944.00
210201	Тэтгэврийн даатгал	38,643,044.52	43,436,751.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,774,095.88	4,833,978.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,815,813.03	3,867,182.95
210204	Ажилгүйдлийн даатгал	952,510.06	966,795.74
210205	Эрүүл мэндийн даатгал	9,542,418.97	9,674,235.27
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,426,087.11	8,786,126.70
210301	Гэрэл, цахилгаан	2,862,991.57	2,691,172.10
210302	Түлш, халаалт	5,530,175.54	5,004,839.61
210303	Цэвэр, бохир ус	1,032,920.00	1,090,114.99

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,681,279.88	20,834,503.87
210401	Бичиг хэрэг	5,273,578.00	5,289,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,177,926.00	7,813,711.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,184,260.88	1,331,712.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	245,800.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,799,715.00	6,299,630.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,913,100.00	3,881,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,805,800.00	1,830,000.00
210604	Урсгал засвар	107,300.00	2,051,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,980,400.00	208,000.00
210702	Дотоод албан томилолт	1,980,400.00	208,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	95,601,880.17	37,807,620.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,485,030.17	30,796,080.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,520,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	831,300.00	1,199,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,300.00	71,620.00
210807	Газрын төлбөр	126,720.00	126,720.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,526,730.00	5,613,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	50,000,800.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,447,000.00	2,089,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,447,000.00	2,089,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>98,731,622,747.29</b>	<b>75,655,210,889.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	63,641,872,235.49	66,887,964,417.92
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	63,554,880,096.06	66,844,619,401.86
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,520,220.00	9,973,298.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,795,319.43	33,371,718.06
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,676,600.00	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	35,089,750,511.80	8,767,246,471.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,089,750,511.80	8,767,246,471.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,482,475,804.37</b>	<b>1,408,475,806.32</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	2,482,475,804.37	1,408,475,806.32
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	2,979,855,008.33	5,462,330,812.70
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	5,462,330,812.70	6,870,806,619.02

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	68,618,838,000.00	67,469,832,089.33
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	68,618,838,000.00	67,469,832,089.33
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	641,066,800.00	618,145,389.47
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	490,879,400.00	482,044,844.50
210101	Үндсэн цалин	360,047,100.00	356,252,002.90
210102	Нэмэгдэл	101,886,700.00	98,959,049.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,185,600.00	21,533,794.40
210104	Урамшуулал	5,760,000.00	5,299,998.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	63,814,700.00	62,778,944.00
210201	Тэтгэврийн даатгал	44,179,500.00	43,436,751.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,908,800.00	4,833,978.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,927,000.00	3,867,182.95
210204	Ажилгүйдлийн даатгал	981,800.00	966,795.74
210205	Эрүүл мэндийн даатгал	9,817,600.00	9,674,235.27
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,600,000.00	8,786,126.70
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,691,172.10
210302	Түлш, халаалт	5,500,000.00	5,004,839.61
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,090,114.99
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,415,300.00	20,834,503.87
210401	Бичиг хэрэг	5,328,900.00	5,289,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,823,900.00	7,813,711.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,331,712.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	262,500.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,500,000.00	6,299,630.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,200,000.00	3,881,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,100,000.00	1,830,000.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	2,051,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,994,000.00	208,000.00
210702	Дотоод албан томилолт	1,994,000.00	208,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	47,163,400.00	37,807,620.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,078,200.00	30,796,080.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1,200,000.00	1,199,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	71,620.00
210807	Газрын төлбөр	250,000.00	126,720.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,355,200.00	5,613,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,000,000.00	1,804,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,804,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	67,977,771,200.00	66,851,686,699.86
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	67,977,771,200.00	66,851,686,699.86
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	67,970,271,200.00	66,844,619,401.86
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,500,000.00	7,067,298.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	68,618,838,000.00	34,854,472,306.24
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	15,592,894,400.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	15,592,894,400.00	
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	53,025,943,600.00	34,835,630,492.74
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	53,025,943,600.00	34,835,630,492.74

120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	18,841,813.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		17,790,958.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,050,854.54
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		5,462,330,812.70
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		6,870,806,619.20
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	1.00	1.00
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	40.00	39.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	32.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>40.00</b>	<b>39.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34.00	33.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>285,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>285,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	285,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	285,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	285,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	285,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын нэгдсэн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор А.Даваасүрэн, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын нэгдсэн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь: Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ. Тайлант онд дэвшүүлсэн зорилт: Эерэг хандлага цахим үйлчилгээний хөгжүүлэлт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжтэй мөн хяналтыг дээд шатны байгууллагаас хэрэгжүүлэн ажилладаг байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын нэгдсэн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 64,216.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 642.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 449.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Авлагын дансны үлдэгдэл 8,462.1 сая төгрөг болж 2,036.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны 160 ажил олгогчоос авах 985.5 сая төгрөгийн НДШ-ийн авлага, 2020 онд цар тахалтай холбоотой Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу 600 гаруй ажил олгогч, 4286 сайн дурын даатгуулагчдын НДШ-ийн хөнгөлөлтийг улсаас авах 7,476.1 сая төгрөгийн татаас санхүүжилтийг бүртгэснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33.1 сая төгрөг болж 3.2 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 653.7 сая төгрөг болж 42.2 сая төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь 5.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж Нийгмийн даатгалын ерөнхий газраас шилжүүлж авсан, 59,550.0 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийн үнийг дахин шинэчилж 12.4 сая төгрөгийн ашиглалтын хугацаа сунгаж орлого авснаар нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 105.9 сая төгрөг болж 40.9 сая төгрөгөөр буурсан нь 289 ажил олгогчийн 29.3 сая төгрөг, 1537 сайн дурын даатгуулагчийн 52.5 сая төгрөг өмнөх оны чөлөөлөлтөөс хасагдсан, 0-3 настай хүүхдээ асарч буй иргэдийн 10.8 сая төгрөгийн өмнөх оны чөлөөлөлт тайлант онд шилжүүлснээс нэмэгдсэн, иргэдийн тэтгэмж, тэтгэврийн даатгалын илүү төлөлтөөс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 27,880.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 22,998.2 сая төгрөгөөр буурсан нь бараа, ажил үйлчилгээний зардал буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 68,618.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 68,618.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 68,618.8 сая төгрөгийн төсөв баталснаас 15,592.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 53,025.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 36,041.7 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 76.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 1.0 мянган төгрөг, хүүгийн орлого 9.5 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 41,552.6 сая төгрөг,

нийт 77,681.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 68,914.5 сая төгрөг буюу 88.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 8,767.2 сая төгрөгийн татан төвлөрүүлэх хийгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дорнод аймгийн дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 0.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд хуулийн хугацаанд бүх мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “ Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 103.0 сая төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитад анхаарах асуудалгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар илэрсэн алдаа зөрчилгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.